



Jetfinance
Non Bank financial Institution

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 он

Танилцуулга

- **2012 он** – Салхитгол ББСБ нь хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, 5 хувьцаа эзэмшигчтэй болж, нэрээ өөрчилж, Жэтфинанс ББСБ болсон. Дүрмийн сангийн хэмжээг нэмж, 525,0 сая төгрөг болсон. БСХСангаас 260,0 сая төгрөгийн бөөний зээлийн эх үүсвэрийг авч дамжуулан зээлдүүлж, хугацаандаа төлж дууссан.
- **2013 он** – Жэтфинанс ББСБ нь дүрмийн сангийн хэмжээг 820,0 сая төгрөг болгож нэмэгдүүлэв.
- **2014 он** – Дүрмийн сангийн хэмжээг 1,0 тэрбум болгож, итгэлцлийн үйлчилгээний эрх авав. БСХСангаас 120,0 сая төгрөгийн бөөний зээлийн эх үүсвэрийг нэмж авч, дамжуулан зээлдүүлж, хугацаандаа төлж дууссан.
- **2015 он** – Дүрмийн сангийн хэмжээг 1,286.5 мян.төгрөг болгож нэмэгдүүлсэн. БСХС-аас 400,0 сая төгрөгийн бөөний зээлийн эх үүсвэрийг авч, төслийг амжилттай хэрэгжүүлж, эргэн төлөлт 2018 оны 4 дүгээр сард хугацаандаа бүрэн төлж дууссан.
- **2016 он** – Дүрмийн сангийн хэмжээг хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж, 1, 720,0 мян.төгрөг болгов.
- **2017 он** – Дүрмийн сангийн хэмжээг хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж, 2,0 тэрбум төгрөг болгов.
- **2018 он** – Дүрмийн сангийн хэмжээг хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж, 2,4 тэрбум төгрөг болгов. Өөрийн оффисийн байртай болж, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг гаргуулсан.
- **2019 он** – ХХБ- тай гэрээ байгуулж, 220,0 сая төгрөгийн зээлийн шугамын эрх нээлгэсэн.

- **2020 он** – Хувьцаа эзэмшигчдийн тоо 3 болов.
- **2021 он** – Хувьцаа эзэмшигчдийн тоо 2 болов.
- **2021 он** - Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрлөө авч, үнэт цаасны арилжаанд оролцож эхэлсэн.
- **2021 он** – Факторингийн үйл ажиллагаагаа жигдрүүлж, явуулж эхэлсэн.
- **2022 он** - Хувьцаа эзэмшигчдийн тоо 3 болж, дүрмийн сангийн хэмжээ 4,4 тэрбум болов. 5 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ байгуулагдав.
- **2023 он** – Бүртгэлийн Me Core программыг нэвтрүүлж, технологийн шинэчлэлийг хийсэн.
- **2023 он** - ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л журам, зааврыг бүрэн боловсруулж, батлуулсан.
- **2024 он** – Дүрмийн сангийн хэмжээ 5,0 тэрбум төгрөг болов.
- **2025 он** – Дүрмийн сангийн хэмжээ 5,3 тэрбум төгрөг болов.

Зорилго зорилтууд

• Эрхэм зорилго

“Жэтфинанс” ББСБ-ын ЭРХЭМ ЗОРИЛГО нь харилцагчдын эрэлт шаардлагад нийцсэн санхүүгийн орчин үеийн үйлчилгээг цаг алдалгүй харилцагчдад хүргэж, хувь хүн, хуулийн этгээдийн хөгжилд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн төлөвлөсөн өгөөжийг нэмэгдүүлж, бичил санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх замаар МУ-ын эдийн засгийн хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрийг оруулах болно.

• Зорилтууд

- Харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, харилцагчдын сэтгэл ханамжийн баталгааг хангах,
- “Жэтфинанс ББСБ” ХХК-ийн нэр хүнд, үнэ цэнийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх, санхүүгийн зах зээлийн шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх,
- Байгууллагын ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх
- Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үр ашгийг хамгийн өндөр түвшинд хүргэх

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



Т.Цогзолбоо
ТУЗ-ийн дарга

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оны 5 дугаар сараас компанийн ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна. IT инженер мэргэжилтэй. 9 жил IT инженерээр банк санхүүгийн байгууллагад ажиллаж байна.



З.Мөнхзаяа
ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оны 5 дугаар сараас компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Банк санхүүч мэргэжилтэй. 29 жил банк санхүүгийн байгууллагад ажиллаж байна



Э.Ариунтөгс
ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оны 5 дугаар сараас компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Нягтлан бодогч, Эрх зүйч мэргэжилтэй. 16 жил банк санхүүгийн байгууллагад ажиллаж байна.



Б.Өлзийбаяр
ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оны 12 сараас компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Нягтлан бодогч мэргэжилтэй. 14 жил банк, санхүүгийн байгууллагад ажиллаж байна.



Г.Ариунбилэг
ТУЗ-ийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2023 оны 4 дүгээр сараас компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Нягтлан бодогч мэргэжилтэй. 8 жил банк, санхүүгийн байгууллагад ажиллаж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

• ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Дарга: Т.Цогзолбоо Гишүүд : З.Мөнхзаяа, Э.Ариунтөгс

Тус хороо нь ББСБ-ын гүйцэтгэх удирдлагын зүгээс зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн болон компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй бүхий л эрсдэлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд удирдлагаар хангах зорилготой.

• АУДИТЫН ХОРОО

Дарга: Э.Ариунтөгс Гишүүд: Б.Өлзийбаяр, Т.Цогзолбоо

Тус хороо нь ББСБ-ын санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд ББСБ-ын зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон ББСБ-ын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудитуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх юм.

• УРАМШУУЛЛЫН ХОРОО

Дарга: Б.Өлзийбаяр Гишүүд: Г.Ариунбилэг, Т.Цогзолбоо

Тус хороо нь хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, ББСБ -д үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд ББСБ-ын цалин урамшууллын бодлого, чадварлаг ажилтан, менежерийг ажилд авах, улмаар тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулан хөгжүүлэх замаар ББСБ -ын бизнесийн зорилтдоо хүрэх, тогтвортой бизнесийн хөгжилд хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хороод ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа.

2025 оны ажлын тайлан

2025 онд ТУЗ-ийн хурал 4 удаа хуралдаж эдгээр хурлаар:

- 2024 оны үйл ажиллагааны тайлан болон 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хэлэлцэж, ХЭ-ийн хуралд танилцуулсан.
- 2025 оны бизнес төлөвлөгөө, төсвийг батлав.
- Жэтфинанс ББСБ” ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 100 хувь ногдол ашиг хуваарилахаар болж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсан.
- Дүрмийн сангийн хэмжээг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлсэн.
- Татварын буцаалтыг ногдол ашгаар олгох тухай хэлэлцэж, шийдвэрлэсэн.
- Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж, комплайнсын хяналтын бүтцийг Э.Ариунтөгс, Г.Ариунбилэг нарын бүрэлдэхүүнтэй томилохоор болов.
- Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж, 2025.10.23 – 10.24-ний өдрүүдэд Комплайнс Удирдах ажилтны манлайлал сэдэвт онлайн сургалтанд ТУЗ-ийн гишүүн З.Мөнхзаяа оролцсон. 2025.08.22 болон 2025.11.15-ны өдрүүдэд ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарт салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг, хариуцлага, эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэх сургалтыг ТУЗ-ийн гишүүн Г.Ариунбилэг явуулсан.
- ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг баталсан.
- 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэхээр “Силвер соробан аудит” ХХК-ийг сонгосон.
- Байгаль орчны салбар руу хандсан нийгмийн хариуцлагын хүрээнд мод үржүүлгийн газар, эсгийн бүтээгдэхүүний үйлдвэр болон монгол арьсан эдлэлийн үйлдвэрүүдэд ногоон зээл олгож, зээлийн эргэн төлөлт маш сайн төлөгдөж байгаа. 2025 оны үйл ажиллагаанд ТУЗ-аас байгал орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байхгүй гэж дүгнэж байгаа.
- 2025 оны 2 дугаар улиралд ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргаас Эрх бүхий албан тушаалтан болон боловсон хүчний тодорхойлолтыг шинэчлэн авч, СЗХ-нд цахим шуудангаар илгээсэн.
- 2025 онд хуралдсан ТУЗ-ийн хуралд гишүүд бүгд 100 хувийн ирцтэйгээр оролцож, аливаа дэвшүүлж буй санал, асуудалд бүгд идэвхитэй оролцож, өөрсдийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлж, гишүүдийн тавьсан санал хүсэлтийг хүлээн авч, асуудлыг шийдвэрлэсэн.

Гүйцэтгэх захирлын үндсэн цалин, урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур

Гүйцэтгэх захирлын болон удирлагын цалин урамшууллыг жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусгасан доорхи үзүүлэлтийн биелэлтийн хэрэгжилтээс хамаарч, ТУЗ-аас тогтоож олгоно.

Үүнд:

- Санхүүгийн төлөвлөгөөний биелэлт
- Үйл ажиллагааны тогтвортой байдал
- Зардлын хэмнэлт, үр ашигтай байдал
- СЗХ-ны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

Компанийн засаглал

“Жэтфинанс ББСБ” ХХК нь Монгол улсад бүртгэлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан ББСБ ба Монгол улсын бүхий л хууль тогтоомж болон банкнаас бусад зохицуулалттай салбарын зохицуулагч Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодексийн зарчмуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Компанийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах зорилгоор хувьцаа эзэмшигч, ажилтнууд, хөрөнгө оруулагч болон бусад бүхий л оролцогч талуудтай эрх тэгш, нээлттэй, ил тод хамтын ажиллагааг эрхэм зорилго болгон ажиллаж байна.

СЗХ-ны “Компанийн засаглалын кодексийн зайны үнэлгээ”-гээр манай компани хангалттай үнэлгээ авч ажиллаж байгаа ба цаашид үнэлгээгээ илүү сайжруулж, засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

Дотоод аудитын тогтолцоо

Дотоод аудитын зорилго

Дотоод аудит хариуцсан ажилтан “Жэтфинанс ББСБ” ХХК-ийн компанийн засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө, үр ашигт байдалд хараат бус, бодитой, эрсдэлд суурилсан үнэлгээ хийж, тэдгээрийн тасралтгүй үйл ажиллагааг сайжруулахад чиглэж ажилладаг. Энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан байгууллагын үнэ цэнийг бий болгох, үнэ цэнээ хамгаалж хадгалах чадавхыг бэхжүүлэхэд оршино. ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоодын болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ий гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудитуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх.

Дотоод аудитын тогтолцоо

1. Аудитын хороо нь дотоод аудитын дүрэм, эрсдэлд суурилсан жилийн аудитын төлөвлөгөө, төсөв болон нөөцийн төлөвлөгөө, дотоод аудит хариуцсан ажилтны томилгоо ба чөлөөлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, гадаад чанарын үнэлгээ, сайжруулалтын төлөвлөгөө, мөн хараат бус байдал зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
2. Аудитыг сонгох, аудитын хамрах хүрээ, зорилго, шалгуур үзүүлэлт, аудитын шалгах давтамж, тайлангийн агуулгыг тодорхойлохдоо компанийн нөлөөллөөс ангид байна. Ингэснээр хараат бус, бодитой хандлагыг бий болгоно. Хараат бус, бодитой хандлага алдагдсан эсвэл алдагдах нөхцөл үүссэн тохиолдолд Аудитын хороонд нэн даруй мэдэгдэнэ.